



СОЁМБО МЭДЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.03.30 №19 (19)

ХОС ТАНГАРАГТАН, ЦАГААН НӨМРӨГТ БААТРУУДДАА БАЯРЫН МЭНД ХҮРГЭЭ



Өнөөдөр Дэлхийн эмч нарын өдөр тохиож байна. Эл өдрийг анх 1933 оны гуравдугаар сарын 30-ны өдөр АНУ-д тэмдэглэсэн ч 1990 оны гуравдугаар сарын 30-ны өдрөөс албан ёсоор "Үндэсний эмч нарын өдөр" болгон эмч нартаа баярлаж талархсанаа илэрхийлдэг

олон улсын өдөр болон өргөжсөн түүхтэй. Энэ өдөр цагаан нөмрөгт баатруудын гавьяаг алдаршуулах, магтан дуулах өдөр хэдий ч тэд энэ цаг мөчид дэлхий дахинаа аюулын харанга дэлдэж буй цар тахалтай нойр хоолоо умартан тэмцэж байна. Цэргийн тангаргийг эмчийн

тангарагтай хослуулан өргөсөн цэргийн эмч нар ч мөн адил улс, эх оронд тохиосон хүндхэн цаг үед ачааны хүндийг үүрэлцэн, үүргээ хариуцлагатайгаар биелүүлж байгаа билээ. Ард түмнийхээ эрүүл энхийн манаанд зогсож байгаа Цэргийн төв эмнэлгийн эмч нар болон Зэвсэгт

хүчний нэгтгэл ангийн эмч нартаа Олон улсын эмч нарын баярын мэндийг хүргээд, эрүүл энх, аз жаргал, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөж, эрдэнэт хүмүүний эрүүл мэндийг хамгаалах ариун үйлс, нөр их хөдөлмөрт тань улам их амжилт хүсье.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 6°C	☁️ -5°C

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 40°C	☁️ 25°C

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20°C	☁️ 0°C

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2,845.0	2,858.0
EUR 🇪🇺	3,332.0	3,397.0
CNY 🇨🇳	433.40	437.70
RUB 🇷🇺	36.66	38.42
JPY 🇯🇵	25.82	26.45
KRW 🇰🇷	2.45	2.58

КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	575
НИЙТ БҮРТГЭГДСЭН	7589
ЭДГЭРСЭН	4711
НАС БАРСАН	10

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	15
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	236
ЭДГЭРСЭН	1123
НИЙТ БАТЛАГДСАН	1359

ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.30
/МЯГМАР ГАРАГ/

ХАВРЫН ДУНД ЦАГААГЧИН ТУУЛАЙ САРЫН ЕСӨН УЛААН УЛААГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулвал:
ӨНГӨ ҮС ДОРОЙТНО

Наран ургах, шингэх:
06.35-19.19

Барилдлага: **ХҮЧИН ТӨГСӨХ**

Шүтэн барилдлага: **ХУРДАН ҮЙЛДЭХҮЙ**

Суудал: **ШОРОО**

Аргын тооллын 3 сарын 30, Ангарга гараг. Билгийн тооллын 17, тэргүүн дагуул одтой улгаачин үхэр өдөр. Өдрийн наран 6.35 минутад мандан 19.19 минутад жаргана. Тухайн өдөр могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж биеэ энхрийлүүштэй. Эл өдөр Буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, мал арилжих, буг дагах, газрын ам бооход сайн. Эрдэнийг гадагш өгөх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой.

ЦАХИМ ШУУДАНД

ДЕСАНТТАЙ ЗАХ НИЙЛЭЭГҮЙ НӨХЦӨЛД...

Зэвсэгт хүчний 334 дүгээр анги



"Ангийн байнгын байрлалыг хориглон хамгаалах байлдааны ажиллагаа-Десанттай зах нийлээгүй нөхцөлд" хэмээх сонирхолтой сэдвийн хүрээнд Мотобудлагын ротын байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг Зэвсэгт хүчний 334 дүгээр анги түүхэндээ анх удаа зохион байгуулав.

Ангийн байлдааны бэлэн байдлын жигдрэлтийн ажиллагааны түвшнийг тогтоон үнэлэх, офицеруудын гал удирдах, ахлагчийн бүрэлдэхүүний буудлага явуулах дадлагыг нэмэгдүүлэх, хээрийн сургалтын жигдрэлт, бие бүрэлдэхүүний бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийг дээшлүүлэх зорилготой уг сургалтыг 2020-2021

оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний хүрээнд 10 км-ийн марш, тактик жагсаалын бэлтгэл хичээлийг цогц хэлбэрээр хоёлуулан явуулсан юм.

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн буудлагын талбай, материаллаг баазыг түшиглэн явуулсан тус байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургууль нь ангийн түүхэнд анхны гэдэг утгаараа онцлог бөгөөд бие бүрэлдэхүүний хээрийн онол, дадлага, мэдлэг чадвараа нэмэгдүүлсэн өндөр ач холбогдолтой сургууль болж чадлаа.

Сургалт дадлагыг Улсын онцгой комиссын гаргасан халдвар хамгааллын дэглэмийг мөрдлөг болгон явуулсан юм.

ТУСГАЙ РОТЫН АЛБА ХААГЧИД АЙЛ ӨРХҮҮДЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЛЭЭ

Зэвсэгт хүчний 325 дугаар анги

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 328 дугаар тусгай ротын бие бүрэлдэхүүн нийгмийн хариуцлагынхаа хүрээнд Ковид-19 цар тахал дэгдэж буй энэ цаг үед Увс аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран амьжиргааны түвшин доогуур, өрхийн орлого буурсан Зүүнговь сумын 8 өрхөд түлш, гурил, будаа, элсэн чихэр, ургамлын тос зэрэг хүнсний

бүтээгдэхүүнийг 100 мянган төгрөгийн хамт өгч дэмжлэг үзүүлээ.

Тус тусламжийн ажиллагааны хүрээнд Увс аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Цэргийн штабын дарга, дэд хурандаа Т.Тогтохбаяр Батлан хамгаалах яам болон Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлан яриа таниулгыг хийлээ.



Ахмад Б.НАРАНЦОГТ

УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС

БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДАЛД ШИЛЖҮҮЛЭХ
ЭМЯ-НЫ САНАЛЫГ ДЭМЖИВ

Коронавируст халдварын цар тахлын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан Эрүүл мэндийн яамнаас халдварын эсрэг авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөний саналаа өчигдөр Улсын онцгой комисст танилцуулав.

Уг саналд 2021 оны 4 дүгээр сарын 3-ны өдрөөс 4 дүгээр сарын 18-ны өдөр хүртэлх хугацаанд "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдал", эрсдлийн улаан түвшинд шилжих тухай тусгажээ. УОК-оос тус саналыг дэмжиж, Монгол Улсын Засгийн газарт танилцуулахаар болов.

ЦЭРГИЙН ШТАБ 100 ЖИЛД

"МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР"-ИЙГ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭВ

Завхан аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб



Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу Завхан аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн цэргийн байгууллагуудыг хамруулан тэдний хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах, бие бүрэлдэхүүний ур чадвар, албаны бэлэн байдлыг дээшлүүлэх, байгууллагынхаа онцлог, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах боломжийг нээж өгөх зорилгоор баярын арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлээ.

Арга хэмжээний хүрээнд Монгол Улсын баатар, армийн генерал Батын Дорж агсны хөшөөнд цэцэг өргөж, нэгдсэн тооллого, баярын хурал, аймагт үйл ажиллагаа явуулж буй төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын нэгдсэн баярын концертыг зохион байгууллаа.

Мөн марш тактикийн аварга тасаг, мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээн, спортын цогцолбор тэмцээнийг

8 төрлөөр амжилттай зохион байгуулав. Марш тактикийн аварга тасаг тэмцээнд 6 байгууллагын 6 тасаг оролцсоноос Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн дэслэгч Ц.Тогтохбаатар ахлагчтай тасаг, 274 дүгээр тусгай ротын ахлах дэслэгч Б.Болд-Эрдэнэ ахлагчтай тасаг, Хилийн цэргийн 0277 дугаар ангийн хошууч А.Ажаргал ахлагчтай тасаг эхний гурван байрт шалгарлаа.

Мэргэжлийн аварга офицер, ахлагч шалгаруулах тэмцээнийг эрэгтэй офицер, ахлагч, эмэгтэй офицер ахлагч гэсэн 3 төрлөөр зохион байгуулахад нийт 36 офицер, ахлагч оролцсоноос эрэгтэй офицерын төрөлд Аймгийн Онцгой байдлын газрын ахлах дэслэгч Б.Базарпүрэв, Аймгийн Цагдаагийн газрын дэслэгч Г.Амарбуян, Хилийн цэргийн 0277 дугаар ангийн дэслэгч Н.Ганбат, эрэгтэй ахлагчийн төрөлд Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн ахлах ахлагч Д.Даваадалай 274 дүгээр тусгай ротын дэд ахлагч Б.Энхбаяр, Хилийн цэргийн 0277 дугаар ангийн дэд ахлагч Х.Ганболд, эмэгтэй цэргийн

алба хаагчийн төрөлд Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн дэслэгч Отгонбаяр, 274 дүгээр тусгай ротын дэд ахлагч Б.Хонгорзул, Аймгийн Онцгой байдлын газрын дэд ахлагч Г.Батцэцэг нар тус тус эхний гурван байрт шалгарлаа.

Спортын цогцолбор тэмцээнийг сагсан бөмбөг, 3x3 сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, шатар, даам, дартс, бильярд гэсэн 8 төрлөөр зохион байгуулахад 13 байгууллагын давхардсан тоогоор

600 гаруй тамирчин төрөл тус бүрд хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж аваргуудаа тодрууллаа. Багийн дүнгээр 17 оноогоор Зэвсэгт хүчний 325 дугаар анги тэргүүн байр, 28 оноогоор аймгийн Цагдаагийн газар хоёрдугаар байр, 38 оноогоор аймгийн Хилийн 0277 дугаар анги гуравдугаар байрт тус тус шалгарав.

Мөн Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийн нэрэмжит буудлагын тэмцээнийг аймгийн төрийн цэргийн байгууллагуудын удирдлагуудын тунд зохион байгууллаа. Буудлагын тэмцээнд Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн захирагч, хурандаа Г.Чулуунзагд тэргүүн байр, аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Г.Үнэнбаяр дэд байр, аймгийн ШШГГ-ын Цагдан хорих байрын дарга, ахмад Ц.Цэдэндамба гуравдугаар байрт тус тус шалгарлаа. Дээрх уралдаан тэмцээн, арга хэмжээнүүдийг COVID-19 цар тахлын дэглэм журмын дагуу зохион байгуулж явуулсан юм.

Хошууч Г.БАВУУДОРЖ

ЦАХИМ ШУУДАН

ГАЗАР ЭЗЭМШИХ
ГЭРЧИЛГЭЭ
ГАРДУУЛАВ

Зэвсэгт хүчний 013 дугаар анги



Ангийн "Ахлагчийн зөвлөл"-өөс санаачлан ахлагч нарын нийгмийн хамгааллыг дэмжих зорилгоор Сонгинохайрхан дүүргийн газрын албатай хамтран нэг офицер, долоон ахлагч, хоёр ажилтан, алба хаагчдад газар эзэмших гэрчилгээ олголоо.

Гэрчилгээг "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын хурлын үеэр гардуулав.

Хошууч С.БАТБААТАР

ШҮЛГИЙН
УРАЛДААНЫ
ШИЛДГҮҮДИЙГ
ШАЛГАРУУЛАВ

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан хугацаат цэргийн алба хаагчдын дунд зохион байгуулсан "Би эх орны хүү" шүлгийн уралдааны шилдгүүдийг шалгарууллаа.

Тус уралдаанд байлдагч Д.Очир-Эрдэнэ "Би эх орны хүү" шүлгээрээ тэргүүн байр, байлдагч Т.Төрболд "Хөх толбот хөвгүүд" шүлгээрээ тусгай байр эзэлж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа. Шагналыг аймгийн Цэргийн штабын дарга, дэд хурандаа Т.Төмөрчөдөр гардуулж өглөө.

Дэслэгч Ц.БАДАМСҮРЭН

ЭНХИЙГ
САХИУЛАГЧИД
ХҮМҮҮНЛЭГИЙН
ТУСЛАМЖ
ҮЗҮҮЛЭВ

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын мандаттай UNMISS энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй хурандаа Д.Энхбаатар захирагчтай Монгол Улсын Зэвсэгт хүчний 10 дугаар ээлжийн баталионы бие бүрэлдэхүүн гал түймэрт өртөж орон гэргүй болсон болон хүндээр өвчилсөн мөрдэс нэгт нөхөддөө туслах зорилгоор хандивын аян өрнүүлжээ.

Хандивыг цэргийн багийн ар гэрийн зөвлөлийн тэргүүлэгч Д.Өнөрцэцэг дээрх цэргийн алба хаагчдын ар гэрт гардуулан өгч, сэтгэл санааны дэмжлэг үзүүлээ.

ЦАГ УЕ

ВАКЦИН ХИЙЛГЭСНИЙ
ДАРАА ШИНЖИЛГЭЭГЭЭР
КОРОНАВИРУСТЭЙ ГАРАХГҮЙ

Нийслэлийн лавлагаа, мэдээллийн 1800-1200 тусгай дугаар 24 цагаар иргэдийн асуултад хариулт өгч, үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгвэл өнгөрсөн амралтын өдрүүдэд буюу энэ сарын 26-28-нд иргэдээс нийт 623 дуудлага ирлээ. Иргэдээс ирүүлсэн дээрх дуудлагын 192 буюу 30.8 хувийг машин ачилт, 96 буюу 15.4 хувийг төрийн байгууллагын үйлчилгээ, хаяг, утас, байршил, 94 буюу 15.1 хувийг орон нутаг руу зорчих хөдөлгөөний талаарх мэдээлэл эзэлж байна. Тус дугаарт коронавирсийн эсрэг вакцинтай холбоотой иргэдээс түгээмэл ирж буй асуултад мэргэжилтнүүд ийн хариулж байна.

Вакциныг ямар хүмүүст хийж байгаа вэ?

-Вакцины нөөц хязгаарлагдмал байгаатай холбоотой Засгийн газраас хамгийн түрүүнд төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн

байгууллагын ажилтан, халдварын голомтод ажиллаж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, цэрэг, мэргэжлийн хяналтын ажилтан, архаг хууч өвчтэй, өндөр настай хүмүүсийг нэн тэргүүнд хамруулж байна.

Вакцин хийлгэсний дараа вирус илрүүлэх шинжилгээгээр вирусгүй гарах уу?

-Үгүй. Вакцин хийлгэсний дараа халдвар авсан эсэхийг илрүүлэх шинжилгээгээр эерэг гарахгүй. Харин дархлааны хариу урвалын нөлөөгөөр эсрэг бие илрүүлэх шинжилгээгээр эерэг гарах боломжтой.

Томуугийн вакцин "Ковид-19"-өөс сэргийлэх үү?

-Үгүй. Гэхдээ томуугийн эсрэг вакцин хийлгэснээр коронавирсийн халдвартай хүн томуугийн халдвар давхар авахаас сэргийлнэ.

Д.СУМЬЯАБАЗАР: ХАЛДВАР
ХАМГААЛЛЫН ДЭГЛЭМЭЭ САЙТАР
МӨРДВӨЛ АЖИЛ АМЬДРАЛ
ТАСАЛДАХГҮЙ, ХАТУУ ХӨЛ ХОРИО
ТОГТООХГҮЙ

UBS телевизийн "Өглөөний мэнд Улаанбаатар" хөтөлбөрийнхөн хотын шуурхай зөвлөгөөн болон хотын даргын холбогдох албаныханд өгсөн үүрэг даалгаврыг шууд дамжуулан хүргэсэн. Энэ үеэр Нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазар иргэдэд хандан дараах уриалгыг хэлсэн юм.

Тэрээр дөрөвдүгээр сард вакцинжуулалтыг эрчимжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Улаанбаатар хотын иргэдээ тавдугаар сарын 5 гэхэд вакцины эхний тунд хамруулж дуусна. Зургадугаар сарын 10-нд багтаж хоёр дахь тунг хийж, зургадугаар сарын 20-ноос хойш Улаанбаатар хотын нийгэм, эдийн засгийн амьдрал шар түвшин рүү шилжих,

халдвар авах хүний тоо эрс багасах үзүүлэлтийг ДЭМБ болон холбогдох мэргэжлийн байгууллагаас өгч байгаа. Иргэн бур, аж ахуйн нэгж, байгууллагууд хариуцлагатай байж, халдвар хамгааллын дэглэмээ сайтар мөрдвөл хотын ажил амьдрал тасалдахгүй, хатуу хөл хорио тогтоохгүй. Үүний төлөө хамтдаа хүчээ нэгтгээд тэмцье, зүтгэе, манлайлъя, нийгэм, эдийн засгаа аваръя, хамгаалъя гэсэн аян өрнүүлж байгаа гэдгээ мэдэгдээд төрөлх хот, бизнес, ажлын байр, хайртай бүхнээ хамгаалахын тулд хувь хүн бүр хариуцлагаа өндөржүүлж, уриалгыг дэмжиж, хамтарч ажиллахыг хүслээ.

ХАЛДВАРЫН ГОЛОМТ БҮХИЙ
БАЙРШЛУУДАД ХАЛДВАРГҮЙТГЭЛ
ХИЙЖ БАЙНА

Халдварын голомт эрс нэмэгдэж байгаатай холбоотойгоор тусгай зориулалтын мананцар үүсгэгч автомашинаар халдварын голомт, болзошгүй байршил, хүн олноор төвлөрч буй автобусны буудал, тоглоомын талбайг халдваргүйтгэх ажлыг тогтмол зохион байгуулж байна.

Тухайлбал, Энхтайваны өргөн чөлөө, Сөүлийн гудамж, Олимпын

гудамж, I төрөх эмнэлэг, "УБ Сонгдо" эмнэлэг, Чингэлтэй дүүргийн VI хорооны голомт хамгаалалт гарсан 23, 39А, 44, 50, 51, 52, 61, 62 дугаар байр, VI хорооны өрхийн эмнэлэг, Баянгол дүүргийн 25 дугаар хороо, "Голден парк" хотхон зэрэг байршилд таван автомашинаар халдваргүйтгэл хийлээ. Үүнтэй зэрэгцэн халдвар илэрсэн албан байгууллагуудад ариутгалыг хийж байгаа аж.



СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 97 дахь жилдээ
хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАДОРЖ

Дарга, ерөнхий
редактор
Хурандаа
САНЖМЯТАВЫН
ТӨМӨРХУЯГ

Эхийг "Соёмбо"
сонин редакцияд
бэлтгэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонин нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонин мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Оффисеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029